



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025 оны 07 сарын 26

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газар /СХГ/-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ЗТЯ-ны Салбарын хяналтын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 75.3 %-тай байна.

/Хүснэгт 1/

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	47	41	92.2
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	1	1	100.0
3	Сайдын тушаалын биелэлт	17	17	76.5
4	ТНБД-ын тушаалын биелэлт	36	36	77.8
5	Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	2	2	30.0
Нийт		103	97	75.3

2.1. СХГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
47	31	2	6	1	1	-	6	92.2

Салбарын хяналтын газар 2025 онд 47 арга хэмжээ хэрэгжүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 41 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 31 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 6 арга хэмжээ, 50%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 92.2 %-тай байна.

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр тус газарт 1 үүрэг даалгавар өгөгдсөнөөс хэрэгжилт **100.0 хувь** байна.

Нийт заалт	Үүнээс		Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй			
1	1	-	-	-	100,0

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Сайдын тушаалаар Салбарын хяналтын газарт өгөгдсөн 17 үүрэг даалгавраас бүрэн хэрэгжсэн 13, хэрэгжээгүй 4 арга хэмжээний дундаж хэрэгжилт 76.5 хувьтай байна. Тус газарт хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй 4 үүрэг даалгавраас “тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай” үүрэг даалгавар бүхий 3 заалт байна.

Нийт заалт	Үүнээс		Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй			
17	13	4	-	-	76.5

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Салбарын хяналтын газарт өгөгдсөн 36 үүрэг даалгавраас бүрэн хэрэгжсэн 28, хэрэгжээгүй 8 арга хэмжээний дундаж хэрэгжилт 77.8 хувьтай байна. Тус газарт хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй 8 үүрэг даалгавраас “тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай” үүрэг даалгавар бүхий 2 заалт байна.

Нийт заалт	Үүнээс		Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй			
36	28	8	-	-	77.8

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс /хувиар/				Хамааралгүй	Биелэлт хувь
		100	70	30	0		
Нийт	2	-	-	2	-	-	30.0

Гурав. Үнэлэлт, дүгнэлт
3.1. Төлөвлөлтийн байдал:

3.1.1. Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу боловсруулаагүй, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөрүүтэй төлөвлөсөн байна. Төлөвлөгөөнд хэрэгжүүлэх хугацааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн боловч зам, тээврийн салбарын хэмжээнд төрийн хяналт шалгалт хангуулж ажиллах арга хэмжээг харилцан адилгүй “зорилтот түвшин”-тэй төлөвлөсөн алдаа гарсан байна.

3.2. Хэрэгжилтийн байдал:

3.2.1. ЗТЯ-ны Салбарын хяналтын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 75.3 %-тай байна.

3.2.2. Салбарын хяналтын газар нь 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг дүгнэхэд Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ хэрэгжилт хангалгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан тогтмол мэдээлэх ёстой хяналт, шалгалтын мэдээлэл болон барилгын байгууламжийн ашиглалтад оруулсны комиссын дүгнэлтийг яамны сайтад байршуулаагүй байна. Мөн Сайдын тушаалаар тус газарт өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 76.5 хувиар үнэлэгдсэн байна.

3.2.3. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 47 арга хэмжээний хэрэгжилт 92.2 % байна. Үүнээс 82,9 % нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 17.1 % нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

3.2.4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт хувь
Зорилт 1. Зам, тээврийн салбарын хяналтын чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	10	83.0
Зорилт 2. Зам, тээврийн салбарын төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.	21	93.3
Зорилт 3. Зам, тээврийн салбарт Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, шалган шийдвэрлэнэ.	6	93.3
Зорилт 4. Зам, тээврийн салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. /Яамны төлөвлөгөө 11.1/	6	98.3
Зорилт 5. Зам, тээврийн салбарын бүтээн байгуулалтын төслийг байнгын ашиглалтад оруулах ажлын хэсэгт	2	100.0

оролцох, зохион байгуулах, хяналт тавина. /Яамны төлөвлөгөө 11.2/		
Зорилт 6. Төмөр зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулна.	1	100.0
Зорилт 7. Зам, тээврийн салбарын хяналт хэрэгжүүлэх нэгжийн улсын байцаагч нарын хүний нөөцийн судалгаа хийх, орон тоо бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрх олгох, сунгах, цуцлах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.	1	100.0

3.2.5. Салбарын хяналтын газраас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орон нутаг дахь зам, тээврийн салбарын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх арга хэмжээг II-III улиралд хийхээр төлөвлөсөн ба ЗГ-аас ирүүлсэн төсвийн хэмнэлтийн хүрээнд хяналт шалгалтаар ажиллах төсвийг танасан нь зарим төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэхгүй хойшлогдох шалтгаан болсон байна.

3.2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн дагуу авто зам, төмөр замын автотээвэр усан замын чиглэлээр “гүйцэтгэлийн”, “төлөвлөгөөт бус”, “урьдчилан сэргийлэх” чиглэлээр хийх хяналт шалгалтын арга хэмжээг эрчимжүүлж ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 82 хувьтай байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

4.1. Салбарын хяналтын газар нь 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг дүгнэхэд Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ хэрэгжилт хангалгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан тогтмол мэдээлэх ёстой хяналт, шалгалтын мэдээлэл болон барилгын байгууламжийн ашиглалтад оруулсны комиссын дүгнэлтийг яамны сайтад байршуулаагүй тул мэдээ, мэдээллийг тухай бүх заасан хугацаанд тогтмол тайлагнах;

4.2. Газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан төлөвлөгөөт хяналт шалгалт хийх арга хэмжээг зам, тээврийн салбарын хэмжээнд хэрэгжүүлж, программ хангамжийн хэвийн ажиллагааг III улиралд багтаан нэвтрүүлэх;

4.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд тус газарт хамаарах үүрэг даалгаврыг ХШҮДАГ-тай хамтран тодорхойлох, үүрэг даалгаврын хэрэгжилтийг тогтмол заасан хугацаанд тайлагнаж, ажиллах;

4.4. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны III улиралд багтаан шинэчлэн батлуулах;

4.5. Үйл ажиллагааны биелэлтийг тайлагнахдаа тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг тайлагнаж, ажиллахыг газрын нийт албан хаагчдад тус тус зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ЗТЯ-НЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН
/хүснэгтээр/**

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	47	41	92.2
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	1	1	100.0
3	Сайдын тушаалын биелэлт	17	17	76.5
4	ТНБД-ын тушаалын биелэлт	36	36	77.8
5	Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	2	2	30.0
Нийт		103	97	75.3

**ЗТЯ-НЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН
/графикаар/**

